



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/87

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.10 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган сумын 6 дугаар багийн Залуус хороолол Ачуут голын мөс хөлдөн халиа тошин үүсэж айл өрх рүү урсаж байгаа тул халиа тошингийн урсац өөрчлөх, далан өндөрлөх ажилд 26,085,400 (хорин зургаан сая наян таван мянга дөрвөн зуу) төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх санхүүжилтийг Байгаль хамгаалах сангийн "Байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардал"-аас гүйцэтгэлийн хувиар санхүүжүүлэхийг Байгаль хамгаалах сангийн нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

